



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/Н

Хажуу шинэ ус

Ажил хүлээлцэх комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 12 дугаар сарын 27-ний өдрийн 634 дүгээр тогтоол, Дундговь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 09 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. 2022 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлсэн Говь-Угтаал сумын шинэ суурьшлын (Наадам, Дэлгэрхонгор, Ар-Ус хороолол) бүсүүдэд 0,4кВ цахилгаан шугамын өргөтгөлийн ажил бүрэн хийгдэж дууссан тул Багануур, Зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх төрийн өмчит хувьцаат компанийн Говьсүмбэр аймаг дахь салбарт хүлээлгэн өгөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Л.Батбаатар (Өрнөлт багийн Засаг дарга)
Нарийн бичгийн дарга:	У.Сүнжидмаа (Нягтлан бодогч)
Гишүүд:	Ё.Болдбаатар (Говьсүмбэр салбарын Ерөнхий инженер)
	Г.Отгончимэг (Говьсүмбэр салбарын нягтлан бодогч)

М.Найдан (Шуурхай үйлчилгээ засварын техникч)

2. 0,4кВ агаарын цахилгаан шугамын өргөтгөлийг Багануур, Зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх төрийн өмчит хувьцаат компанийн Говьсүмбэр аймаг дахь салбарын үндсэн хөрөнгөнд бүртгүүлэхэд шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлж акт үйлдэн хүлээлгэн өгөх ажлыг чанартай зохион байгуулж ажиллахыг Өрнөлт багийн Засаг дарга (Л.Батбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА, ТАРИУНАА



482301014